



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/604

Мөрөн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187, 2023 оны А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/269 дүгээр захирамжаар газар эзэмшигч иргэн Цогнууд овгийн Лхагвасүрэнгийн Дэнсмаа (РЮ89103106)-ын Мөрөн сумын 5 дугаар баг Зах-206 хаягт байршилтай худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттайгаар эзэмшүүлсэн 6712017091 нэгж талбарын дугаартай газрын талбайн хэмжээ 4709м² гэснийг 4805м² гэж өөрчилж үлдсэн 20 жилийн хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/269 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

3. Газар эзэмшигч иргэн Лхагвасүрэнгийн Дэнсмаа (РЮ89103106)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т, Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Р.Машбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ